МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.
18 дахь жилдээ
# МОНГОЛЫН МЭДЭЭ
Хүн ам 3,112.158... УСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.10.25. Мягмар. №190 (4560) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ 100 ХОНОГИЙН АЖЛАА ТАЙЛАГНАВ
II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС
ЦАГААН ТАХЛЫН ХАР СҮҮДЭР НӨМӨРСӨӨР Л...
V нүүрт




Дугаарын 60 мөр

## Нэг л зүйл буруу байна

Б.ДАВАА

Монголд нэг л зүйл буруу яваад байх шиг. Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг шинжлэх ухааны доктор хүн давж гарахгүй бүдэрч байхад “захиалгатай” ажлын туршлагагүй захын нэгэн эрхэм тэнцэж байх юм. Угтаа Төрийн албаны зөвлөл хуулийнхаа дагуу мэргэжлийн хүнийг төрийн албан хаагчийн шалгалт өгч тэнцсэн тохиолдолд төрийн их үйлнээ илгээх ёстой. Гэтэл аль нэг албан тушаалд томилогдоно гэх сураг дуулсан нөхдүүд шууд л тус шалгалтад тэнцэх жишээтэй. Мэдээж, өөрсдийн чадвараар тэнцсэнийг нь үгүйсгэх аргагүй ч, нэр нь яригдаж байсан хүмүүс бүгд Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцэнэ гэдэг санаандгүй хэрэг биш л болов уу. Ядаж нэг нь ч болтугай бүдэрсэн бол итгэхсэн.

Саяхан гэхэд Төрийн албаны зөвлөл Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч 10 агентлагийн даргын сонгон шалгаруулалтыг явуулсан.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# ЗАСГИЙН ГАЗАР “БҮС”-ЭЭ ЧАНГАЛААД Ч БОЛОВ ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭЭСЭЙ



Дэлгэрэнгүйг III нүүрнээс

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



## С.АНХБАЯР: ТОНОГЛОЛЫН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААН ДЭЭР НЭМЭХ НЬ ҮР АШИГ, ЭНЭ Л МИНИЙ ХИЙХ АЖИЛ

“Манай ДЦС Монгол Улсын стандартад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Мэдээж хэрэг бүх зүйл бүрэн төгс шийдэгдсэн гэж би хувьдаа хэлэхгүй. Бид найдвартай, үр ашигтай аль болох байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулахыг гол зорилгоо гэж тодорхойлсон” хэмээн өгүүлж суугаа эрхэм бол “Дулааны цахилгаан станц 4” ТӨХК-ийн дарга С.Анхбаяр. Дашрамд өгүүлэхэд, станцынхаа удирдлагын багт 10 шахам жил ажиллаж, ялангуяа сүүлийн жилүүдэд бодлого төлөвлөлт дээр ажилласан эдийн засагч нэгэн юм билээ. Ингээд түүнтэй цаг үеийн асуудлаар хийсэн ярилцлагаа хүргэе.

Үргэлжлэлийг IV нүүрт







| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2330.00 | 2343.00 | ФУНТ | 2795.00 | 2895.00 |
| ЕВРО | 2501.00 | 2570.00 | РУБЛЬ | 35.80 | 38.90 |
| ИЕН | 22.18 | 22.77 | ЮАНЬ | 343.50 | 347.20 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2328.00 | 2343.00 | ФУНТ | 2809.00 | 2897.00 |
| ЕВРО | 2502.00 | 2581.00 | РУБЛЬ | 36.06 | 39.42 |
| ИЕН | 22.11 | 22.87 | ЮАНЬ | 343.50 | 347.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

СОНГУУЛЬ-2016

# ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД МАН ЯЛАЛТ БАЙГУУЛЛАА

Ж.ОТГОН



Орон нутгийн сонгуулийн нэмэлт санал хураалт өнгөрсөн ням гарагт болж өндөрлөсөн. Тэгвэл Нийслэлийн сонгуулийн хорооноос дүүргийн ИТХ-ын сонгуулийн нэмэлт санал хураалтын талаар өчигдөр сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Мэдээллийн эхэнд Нийслэлийн сонгуулийн хорооноос нэмэлт санал хураалтаар сонгогчдын ирц Багануур 53,4, Баянгол 54.8, Баянзүрх 58.1, Сонгинохайрхан 54.1, Сүхбаатар 54.4, Хан-Уул 56.8, Чингэлтэй дүүрэг 56.6 хувьд хүрсэн болохыг онцолсон юм. Өмнө нь Багахангай, Налайх дүүргүүдэд сонгогчдын ирц бүрдсэнээр нийслэлийн хэмжээнд сонгогчдын ирц 56 хувьд хүрсэн байна. Нийслэлийн хэмжээнд нийт 152 тойрогт сонгуулийн санал хураах үйл ажиллагаа зохион байгуулагджээ. Саналын тоогоор дүүргүүдэд улс төрийн намууд дараах байдлаар ялалт байгуулсан байна. Мандатын тухайд Баянгол, Сонгинохайрхан 41, Баянзүрх 31, Чингэлтэй, Хан-Уул 35, Багахангай 17, Налайх 5, Багануур 25 төлөөлөгч сонгогдохоор хувиарлалт хийгдсэн. Ерөнхий дүнгээрээ нийслэлд АН Баянгол, Баян-Зүрх, Сүхбаатар дүүрэгт ялалт байгуулсан бол МАН бусад зургаан дүүрэгт ялалт байгуулсан байна. Үүнд:

- Баянгол дүүргийн нийт 41 суудлаас АН-31 суудал, МАН-10 суудал авсан бол,
- Баянзүрх дүүргийн нийт 41 суудлаас АН-22, МАН-19,
- Сүхбаатар дүүргийн нийт 35 суудлаас АН-19, МАН-16 суудал авчээ.
- Харин Сонгинохайрхан дүүргийн нийт 41 суудлаас АН-2, МАН-39.
- Хан-Уул дүүргийн нийт 35 суудлаас АН-15, МАН-18 суудал,
- Чингэлтэй дүүргийн нийт 35 суудлаас АН-6, МАН-29 суудал,
- Багануур дүүргийн нийт 25 суудлаас АН-0, МАН-25 суудал,
- Багахангай дүүргийн нийт 17 суудлаас АН-0, МАН-17 суудал,
- Налайх дүүргийн нийт 25 суудлаас АН-4, МАН-21 суудал тус тус авсан байна.

Харин аймгуудын дүн мэдээг СЕХ-ноос мэдээллээ. Аймгуудын ирц 63.2, дүүргийнх 56.3 хувьтай байсан нь улсын хэмжээнд 60.1 хувь нь санал хураалтад оролцсон байна.

**АЙМГУУДЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛБАЛ,**

- Архангай аймаг 19 сумтай. 12 суманд МАН, 7 суманд АН,
- Баян-Өлгий 13 сумтай, МАН бүх суманд ялалт байгуулжээ
- Баянхонгор аймаг 20 сумтай. 14 сум МАН, 6 суманд АН
- Булган 16 сумаас 11 сум нь МАН, 3 суманд АН, 2 суманд дахин санал хураалт явагдана.
- Говь-Алтай аймгийн 13 суманд МАН, 2 суманд АН, 3 суманд дахин санал явуулахаар болжээ.
- Говьсүмбэр аймгийн 3 сумаас 2-т нь МАН, 1 тойрогт нь АН
- Дорноговь аймаг 14 сумаас 11-т нь МАН, 3-т нь АН.
- Дорнод аймаг 14 сумаас 8-д нь МАН, 2-т нь АН, 4 суманд дахин санал хураалт явуулна.
- Дундговь аймаг 15 сумтай. 9-т нь МАН, 5-т нь АН, 1 сумын 9 суудалд бие даагч ялалт байгуулжээ.
- Завхан 24 сумаас 1 суманд МАН, 20 суманд АН ялалт байгуулж, 3 суманд дахин санал хураалт явуулах юм.
- Өвөрхангай аймгийн 19 сумын 14-т МАН, 5-т нь АН
- Өмнөговь аймаг 15 сумаас 12 МАН, 3 сум АН
- Сүхбаатар аймаг 13 сумаас МАН, 8 АН
- Сэлэнгэ аймаг 17 сумын 9 нь МАН, 6 нь АН бол 2 суманд дахин санал хураалт явагдана.
- Төв аймгийн 15 МАН нь, 11 АН-МАХН-ын "Төв нутаг эвсэл", 1 суманд дахин санал хураалт явуулахаар болжээ.
- Увс аймгийн 19 сумаас 18 МАН, 1 сум АН
- Ховд аймгийн 13 сум нь МАН, 3 сум нь АН, 1 суманд дахин санал хураалт явуулахаар болжээ.
- Хөвсгөл аймгийн 23 сумаас 17 МАН, 6 АН
- Хэнтий аймгийн 18 сум, 12 сум МАН, 6 суманд АН суудал авсан байна.
- Дархан-Уул 4 сумтай бөгөөд бүгдэд нь МАН ялалт байгуулжээ.
- Орхон аймаг хоёр сумтай. Мөн л МАН үнэмлэхүй ялалт байгуулсан байна.

Харин нэр дэвшигчдийн санал тэнцсэн хэсгүүд дахин санал хураалт явуулах гэнэ. Сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд 15191 нэр дэвшигч өрсөлдсөн. Тэднээс 117 нэр дэвшигчийн санал тэнцсэн байна. Нийт 19 аймгийн 117 нэр дэвшигчийн дунд дахин санал хураалт явагдана. Дахин санал хураалтыг аравдугаар сарын 29-ний өдөр зохион байгуулна. Төсвийн тухайд одоогоор тодорхой гараагүй байгаа гэнэ. Ингэхдээ батлагдсан зардлын хүрээнд сонгуулийг явуулах бөгөөд нэмэлтээр төсөв гаргахгүй юм байна. Өөрөөр хэлбэл, дахин сонгууль биш дахин санал хураалт явагдах аж.


MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс: 976-70113551**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**


ЗАСГИЙН ГАЗАР-100 ХОНОГ

# ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ 100 ХОНОГИЙН АЖЛАА ТАЙЛАГНАВ



Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат өнгөрсөн пүрэв гарагт Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа. Тэрбээр Монгол Улсын Засгийн газар эмхлэн байгуулагдсаны 100 хоногийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын зүгээс хийж хэрэгжүүлсэн ажил, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний талаар мэдээлэл өгсөн юм. Шинэ Засгийн газар байгуулагдаж салбарын сайд нар ажлаа хүлээж аваад 100 хоног болж байгаа. Энэ хугацаанд зам, тээврийн салбарын харьяа байгууллагуудын ажлуудыг идэвхижүүлж, Монгол Улсын эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг ажлуудад түлхүү анхаарал хандуулж ажиллаж буй талаараа сайд Д.Ганбат онцлов.

Тэрбээр зам, тээврийн салбарт өнгөрсөн жилүүдэд төмөр замын тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж ирсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт удаашралтай байсныг хэлээд ирэх дөрвөн жилд Монгол Улсын Засгийн газраас төмөр замын нэвтрүүлэн өнгөрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, дамжин өнгөрүүлэх тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулахад анхаарч ажиллахаа илэрхийллээ. Мөн Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийх, БНХАУ, ОХУ-ыг холбосон коридорын тоог нэмэгдүүлэх, Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлыг ашиглалтад оруулж, Ази-Европыг холбох гүүр болгох бодлого баримтлан ажиллаж байгаагаа хэлж байв.

Дэлхийн эдийн засгийн хөгжилтэй уялдан Ази-Европын хооронд ачааны урсгал нэмэгдэж буй өнөө үед хоёр тивийг холбосон Монгол Улсын автотээвэр, агаарын тээвэр, төмөр замыг хамгийн дөт тээврийн коридор гэж дэлхий нийт харах болжээ.

Монгол Улсын дэд бүтцийн хөгжил түүний дотор тээврийн салбарын хөгжил улс орны нийгэм, эдийн засагт онцгой ач холбогдолтой учир цаашид ч эрчимжүүлэн хөгжүүлэх шаардлага тавигдаж байна. Төмөр замын тээврээр 2016 оны эхний найман сарын байдлаар 12,377.17 мян.тн ачаа, 7,886.05 мян.зорчигч тээвэрлэсэн судалгаа бий.

Засгийн газрын 100 хоногт төмөр замын тээврийн салбарыг хөгжүүлэх ажлын хүрээнд хэд хэдэн ажлыг хэрэгжүүлж эхэлжээ. Тухайлбал, Эрдэнэт-Овоотын төмөр замын урьдчилсан судалгааны ажил, Монгол–Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн хэрэгцээнд импортлох дизель түлшийг онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуулийг батлуулах, Монгол-Тяньжины худалдаа хамтын ажиллагааны хүрээнд Дунзяны чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт тээвэр логистикийн төв төслийг хэрэгжүүлэх хамтарсан компанийг байгуулах зэрэг ажлуудыг хийжээ. Мөн Бүс нутгийн логистикийн төслийн хүрээнд барилгын ажил эхлүүлэхээр болсон талаараа ч дуулгалаа. Цаашид төмөр замын салбарт "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хүрээнд олон зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байгаа аж. Үүнд, "Шивээхүрэн-Сэхэ", "Тавантолгой-Гашуунсухайт", "Хөөт-Бичигт", "Зүүнбаян-Ханги" чиглэлийн төмөр зам, Оюутолгойн салбар төмөр замын ажлуудыг барьж ашиглалтад оруулах, Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, "Богдхан" төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, "Эрдэнэт-Овоот" чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

Төмөр замын тээврийн салбарт дэврх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр Монгол Улсын экспортын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, тээвэрлэх гол ачаа болох нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын тээврийн зардлыг бууруулах, уурхайн олборлолт, нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, орон нутгийн ажлын байр нэмэгдүүлэх, тээвэр логистикийн дэд бүтцийн сүлжээг хөгжүүлэх зэрэг ач холбогдолтой талаар салбарын сайд онцоллоо.

Монгол Улсын гадаад зах зээлд нэвтрэхэд нэн чухал үүрэгтэй, хөрөнгө оруулагчдыг татах, жуулчдад үйлчлэхэд ихээхэн хувь нэмэр оруулагч, Монгол Улсын эдийн засгийн онцгой салбарын нэг бол иргэний нисэхийн салбар. Тиймээс тус яамнаас агаарын тээврийн дотоод, гадаадын сүлжээг нэмэгдүүлэн, орон нутаг, олон улсын нислэгийн давтамжийг нэмэгдүүлэх, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх, үнэ тарифийг бууруулах, бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлэхэд анхаарч ажиллах юм байна.

Иргэний нисэхийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ жилээс жилд өсч, агаарын навигацийн болон нисэх буудлуудын дэд бүтцийг сайжруулахад сүүлийн 5 жилд гэхэд 150 тэрбум гаруй төгрөг зарцуулсан байгаа талаар Д.Ганбат сайд хэллээ. Хамгийн том хөрөнгө оруулалт болох жилдээ гурван сая зорчигчийг нэвтрүүлэх хүчин чадалтай, 617 сая ам.доллараар байгуулж буй Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын бүтээн байгуулалт бөгөөд энэхүү нисэх буудлыг 2017 оны эхний хагас жилд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөжээ.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нисэх буудлуудын дэд бүтцийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, алслагдсан бүс, орон нутгийн иргэдэд нийгмийн үйлчилгээ хүргэх зорилгоор орон нутгийн нисэх буудлуудыг үе шаттайгаар өргөтгөх, техник, технологийн шинэчлэлтийг нэвтрүүлэх ажлуудыг гүйцэтгэх шаардлагатай байгаа аж.

Мөн тэрбээр ажлаа тайлагнах үеэрээ авто тээврийн салбарт ихээхэн анхаарал хандуулж ажиллахаа илэрхийлсэн. Ингэхдээ автотээврийн хилийн боомтуудыг нээх, зорчигч тээврийн байнгын үйлчилгээг зохион байгуулах, ачаа, зорчигч тээвэрлэх зөвшөөрлийн системийг нэвтрүүлэх, хилийн боомтуудад автотээврийн үйлчилгээг өргөжүүлэх ажлыг зохион байгуулж байгаа талаараа танилцуулав. Энэхүү ажлын эхлэл болгож Тяньжин боомт–Улаанбаатар-Улаан-Үд хотын чиглэлд туршилтын ачаа тээвэрлэлтийг өнгөрсөн наймдугаар сард зохион байгуулсан юм. Мөн Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавирга–Ар хашаатын боомтоор ӨМӨЗО-ны Манжуур хотыг хүртэлх зорчигчдын тогтмол тээврийн маршрутыг ирэх сараас эхлүүлэхээр болжээ.

Түүнчлэн тус яамнаас авто замын бүтээн байгуулалтад шинэ техник, технологи нэвтрүүлэх, бүх аймгийг хатуу хучилттай автозамаар холбох ажлыг эрчимжүүлж байгаа бөгөөд эхний ээлжинд ургац тээвэрлэх замуудын засварчилгааг хийж, ургац тээврийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд анхаарч ажилласан байна.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



АМГТГ-ын нүүрсний хэлтсийн дарга асан Б.Алтсух

ҮЗЭЛ БОДОЛ

# ЗАСГИЙН ГАЗАР "БҮС"-ЭЭ ЧАНГАЛААД Ч БОЛОВ ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭЭСЭЙ

Н.ПУНЦАГБОЛД

Улаанбаатар хотод сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ ямар байгаа билээ. Элдэв тоо баримт дурьдаад, эш татаад байх шаардлага ч байхгүй. Нөхцөл байдал хэцүүхэн байгааг хэн хүнгүй л мэдэж байгаа байх. Тэр дундаа цэцэрлэгийн хүрэлцээ муу. Маш муу байсныг арай л жаахан дээрдүүлж байгаа, сүүлийн жилүүдэд. Нэг хэсэг жилд ганц ч цэцэрлэгийн барилга нэмэгддэггүй байсныг эс тооцвол сүүлийн үед бүр овоо болоод байгаа. Улс боломж бололцооныхоо хэрээр цэцэрлэг барьж, ашиглалтад оруулж байна. Нөгөө талаар цэцэрлэгийн асуудлыг шийдэх гарц хайж байгаа нь өнгөрсөн дөрвөн жилд "Хүүхэд харах үйлчилгээ"-г гаргаж ирсэн явдал байлаа. Ерөөсөө өнгөрсөн дөрвөн жилд эрх баригчдын хийсэн гайгүй ажлуудын нэг нь энэ. Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль батлагдаж, асуудал шийдэгдсэнээр 6000 гаруй хүүхэд гэртээ цоожлогдох аюулаас аврагдаж, мөн тооны эцэг, эх санаа зоволтгүй хөдөлмөр эрхлэх боломж бүрдэж байгаа гэж. Яг таг баталгаатай тоо баримт биш л дээ. Үүнээс илүү ч олон хүүхэд Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах боломжтой байж болох. Гэвч энэ Засгийн газрын үед Хүүхэд харах үйлчилгээ зогсонги байдалд орчихоод байна. Эрх баригчид болохоор бүр зогсоогоогүй, үргэлжлүүлнэ, дэмжинэ гээд л байгаа. Тэгсэн мөртлөө зогсоож байгаа шалтгаанаа янз бүрээр тайлбарлаж байгаа юм. Стандартын дагуу байраа тохижуулаагүй, хүүхэд харах багш нарыг сайн сургаагүй. Ажил нь удаан урагшилж байна гэх мэтээр өөр олон янзын шалтгаан хэлээд байгаа юм. Нөгөө талаас хамгийн хүндрэлтэй байгаа асуудал бол Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдэд олгох хувьсах зардал. Эдийн засаг хүндрэлтэй байгаа болохоор гэх тайлбарыг зүгх хүмүүс ч байгаа юм. Тийм ээ, эдийн засаг хүндрэлтэй байгаа. Бид бүсээ чангалахаас өөр аргагүй байна. Төсвөө дэмий зүйлд үрэн таран хийх эрх үлдээгүй. Гэхдээ Хүүхэд харах үйлчилгээ дэмий гэдэг ангилал руу орохгүй. Харин ч хамгийн шаардлагатай, хөрөнгө мөнгө гаргах ангилал руу орох ёстой. Хууль нь батлагдаад, Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүмүүс нь байр саваа бэлтгээд, дарга нарын шаардлагад арай гэж нийцүүлэх гээд явж байсан. Энэ үйлчилгээг зогсоолгүй, түүний оронд шалгах ёстой юм бол шалгаад, шаардлагад нийцэнд нь хувьсах зардлыг нь олгоод явж байсан бол арай өөр. Одоо болохоор өөх ч биш, булчирхай ч биш байдалтай болчихлоо. Ерөнхий дүр зургийг нь харах юм бол, Хүүхэд харах үйлчилгээг болиулах гээд ч байгаа юм шиг. Албаны хүмүүсийн хэлж, яриад байгааг нь сонсохоор үргэлжлүүлэх гээд байгаа юм уу гэж бодогдохоор. Аль нэг талдаа хараахан гарчихаагүй байна. Шууд үргэлжлүүлэх нь тодорхой гээд хэлчих хэцүү. Янз бүрийн шалтаг, шалтгаан тоочиж байгааг болиулчихвал яах билээ. Зогсоох нь тодорхой гээд хэлчих ч бас хэцүү. Он гаргаад үргэлжлүүлнэ, бүр зогсооно гэж хэн ч хэлээгүй гэхэд л гүйцээ. Угтаа бол нүдээ аниад л хэрэгжүүлэх ёстой юм. Үнэхээр төсөв хэцүү байгаа бол өөр хэрэггүй зардлаа хэмнээд, тэр мөнгөө Хүүхэд харах үйлчилгээнд зарцуулж яагаад болохгүй гэж. Нөгөө талаар янз бүрийн шалтаг хайж, зогсоох чиглэл рүү нь явуулж байхаар нэгэнт л байр саваа бэлтгээд, хөрөнгө мөнгөө зарцуулчихсан хүмүүст эрхийг нь нээлттэй үлдээх хэрэгтэй. Төрөөс хувьсах зардлыг нь өгч чадахаар болтлоо өөрсдөө үйл ажиллагаагаа явуулаад, сардаа 150 мянган төгрөгөөр ч юм уу хүүхэд харах боломжоор нь хангаад өгчих хэрэгтэй. Орон сууцныха хоёр өрөөнд хэдэн ширхэг тоглоом тавьчихаад, өдөр өнжүүлэх ажиллуулж байгаа нь энэ гэд сардаа 220 мянган төгрөгийн төлбөр авч байгаа хүмүүс зөндөө л байна. Эцэг, эхчүүд ажлаа хийхийн тулд мөнгийг нь төлөөд л хүүхдээ харуулж байгаа. Тэгвэл нэгэнт байр саваа бэлтгэчихсэн газруудад бол үүнээс арай бага үнээр хүүхэд харахад яах вэ дээ. Заавал суртэй шаардлага тавиад, түүнийг нь хангахгүй бол эрхийг нь өгөхгүй гээд байх хэрэггүй л баймаар.




### Энэ ч гэсэн хүн амын өсөлтийг дэмжих бодлого

Монгол Улс ердөө л гурвахан сая хүнтэй. Сүүлийн 30-аад жилийн турш хоёрхон саяулаа гэдэг байсныг бодвол арай дээр. Гэвч манай улсын хүн амын өсөлтийн хурд үнэндээ яст мэлхий шиг л байна. Энэ бол хүн амын өсөлтийг дэмжих ямар ч бодлого байхгүй байгаагийн хар гай. Ганц байгаа бодлого нь хүүхдийн 20 мянга гээд байгаа. Ёстой хөх инээд хүрмээр бодлого. Сард 20 мянган төгрөг авахын тулд хүүхэд иргэд хүүхэд гаргана гэж ямар тэнэг нөхрийнх нь толгойд орж ирээд, дараа нь хүн амын өсөлтийг дэмжсэн бодлого гэж ярьдаг байна аа. Харин сүүлийн жилүүдэд арай өөр бодлого яриад байгаа. Өнгөрсөн дөрвөн жилд гурав дахь хүүхдийг дэмжих бодлого гээчийг ярьж ярьж дуусгасан. Харин энэ Засгийн газрын үед "Цалинтай ээж" гэдэг хөтөлбөр гаргаад ирлээ. Уг нь бусад бүх хэрэгтэй хэрэггүй халамжаа хасаад, зөвхөн хүн амын өсөлт рүү чиглэсэн бодлого руу "цутгавал" сайн л байна.

Гэхдээ зөвхөн хэдэн төгрөг өгнө гээд энэ мэт бодлого урагшаа явахгүй нь ойлгомжтой. Хүүхэд төрүүлээд, хоёр жил боллоо, дараа нь цэцэрлэгт өгөх гэхээр л бөөн "дайн" болоод байвал хэцүү биз дээ. Тийм болохоор хүн амын өсөлтийг дэмжих бодлого гаргах гэж байгаа асуудлыг цогцоор нь шийдэх хэрэгтэй. Хүүхэд хоёр нас хүрээд, цэцэрлэгт орох үед эцэг, эхчүүдийн тархи "гашилдаггүй" л байх ёстой шүү дээ. Тэгэхийн тулд "Хүүхэд харах үйлчилгээ"-г улам боловсронгуйболгож,хэрэгжүүлэх нь зөв. Яг үнэндээ сая эрх баригчид хувийн цэцэрлэгийг дэмжиж, баахан хүүхэд авах бололцоогоор хангасан. Нэг талдаа бол эцэг, эхчүүдэд аятай юу л хэрэг. Нөгөө талдаа хувийн цэцэрлэгүүд зүгээр л төлбөргүйгээр, хувьсах зардлаа авахын төлөө баахан хүүхэд авах уу. Төрөөс тодорхой хэмжээнд төлбөр мөнгө өгсөн гэж л хардах гээд байна. Хувийн цэцэрлэгийг энэ мэтээр дэмжиж болж байгаа юм чинь, нэгэнт ажлаа эхлүүлээд явж байгаа Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийг ч дэмжих л хэрэгтэй. Өнөөдөр Улаанбаатар хотын хэмжээнд 40 гаруй мянган цэцэрлэгийн насны хүүхэд гэртээ байна гэсэн тоо бий. Тэдний хэд нь гэртээ цоожлогдож үлдэж байгаа бол. Бас л яс хавталзмаар тоо шүү. Тэд гэртээ үлдэж, асар их эрсдэл дунд байхын оронд Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаад, нэг багшийн хараа хяналт дор байвал арай л өөр биз дээ. Энэ мэтээр бодох асуудал маш их байна. Тийм болохоор төсвөөс хэмнэж болохоор хэмнээд, бүр бүсээ чангалаад ч болов Хүүхэд харах үйлчилгээг үргэлжлүүлээсэй билээ. Олон ч эцэг, эх үүнийг хүсч байгаа нь тодорхой. Энэ ажлыг хийчихвэл их аятайхан харагдах юм даа.

---

Дугаарын 60 мөр

## Нэг л зүйл буруу байна

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Гэхдээ тэдгээр 10 агентлагийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчдийг Засгийн газар өнгөрсөн наймдугаар сарын 5, 10, 17-ны хуралдаанаараа томилчихсон байсан юм. Тодруулбал, наймдугаар сарын 5-нд Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр Л.Бямбасүрэн, 10-нд Татварын ерөнхий газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр Л.Зориг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр Ц.Ням-Осор, Биеийн тамир, спортын газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр Б.Шаравжамц, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр Р.Содхүү, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр Б.Нямдаваа, Үндэсний хөгжлийн газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр Б.Баярсайханыг томилсон. Дараагийн ээлжит хуралдаанаар буюу наймдугаар сарын 17-нд Гадаадын иргэн харьяатын газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр Д.Мөрөн, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр Б.Чинбат, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын үүрэг гүйцэтгэгчээр О.Алтансүхийг томилсон байв. Төрийн албаны зөвлөл эдгээр албан тушаалд сонгон шалгаруулалт явуулж жинхэнэ даргыг нь тодруулах хүртэл ажиллах хүмүүсийг л Засгийн газар томилсон гэсэн үг. Гэтэл Төрийн албаны зөвлөл Үндэсний хөгжлийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Баярсайхан гадаадад албан томилолттой байсан учраас сонгон шалгаруулалтыг нь хойшлуулж, үлдсэнийг нь бүгдийг нь жинхэлж орхив. Тэд бүгдээрээ л Төрийн албаны зөвлөлийн босгыг ядах юмгүй давчихлаа. Засгийн газар ямар ч мэргэшлийн шалгалтад ядах юмгүй тэнцэх хүнийг үүрэг гүйцэтгэгчээр томилчихдог юм бол Төрийн албаны мэргэшлийн шалгалт ямар хэрэг байна уу. Мэргэжлийн, чадвартай удирдлага томилогдсон цагт аливаа салбарын үйл ажиллагаа зөв үргэлжлэх учиртай. Гэтэл саяхан тайзан дээр дуу дуулаад явж байсан дурын дуучин нөхөр төрийн чухал албыг толгойлоод явж байхад тэр салбарын үйл ажиллагаа зөв замаар урагшилна гэдэг зүүний үзүүрт ширхэг будаа тогтоохтой адилхан байх биз. Нийслэлд гэхэд Аялал жуулчлалын газрын дарга болон нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын дэд даргын албан тушаалд "Номин талст" хамтлагийн дуучин Д.Батсүх, А.Хаянхярваа нар томилогдсон. Түүнчлэн, нийслэлийн Соёл, урлагийн газрын даргаар загвар өмсөгч Ж.Дамдинцэрэн, МУГЖ Б.Сарантуяа Соёлын төв өргөөний дэд дарга, мисс Ё.Нямжав Гадаад харилцааны яаманд ДБУААГ-ын даргын албан тушаалд "заларсан". Тэдний албан тушаалд сонгон шалгаруулалт хараахан зарлагдаагүй боловч, тун удахгүй жинхлэх нь тодорхой биз. Шинжлэх ухааны доктор хүн давж гарахгүй байгаа Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг тэд төдөх юмгүй давчихна гэдэгт үнэхээр итгэж чадахгүй л байна. Энэ мэтээр намын сэтэртэй бүхэн тэнцэж, нам бус нь бүдэрдэг юм бол ер нь ТАХ-ын мэргэшлийн шалгалт гэж байгаад ч яах юм, бүр халчихвал дээр биш үү.

## ЭДИЙН ЗАСАГ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

# С.АНХБАЯР:

# ТОНОГЛОЛЫН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААН ДЭЭР НЭМЭХ НЬ ҮР АШИГ, ЭНЭ Л МИНИЙ ХИЙХ АЖИЛ




**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

**-2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангагдсан гэж Засгийн газар мэдээлсэн. Монгол Улсын эрчим хүчний салбарын ачааны хүндийг IY цахилгаан станц үүрч явдгийн хувьд та бүхэн ч гэсэн өвөлд бэлэн үү гэж асуумаар байна?**

-Юуны өмнө танай сонины уншигчдад энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие ажлаа хүлээж аваад нэг сар орчим хугацаа өнгөрч байна. Өмнө нь энэ байгууллагад ажиллаж байсан болохоор станцын ажил байдалтай танилцахад цаг алдсангүй. Ажлаа хүлээж авсан даруйдаа тулгамдаж байгаа асуудлууд түүний дотор өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд анхаарлаа хандуулсан. Өнөөдрийн байдлаар нийт ажилчдын 91.8 хувь нь ээлжийн амралтаа эдлээд ажилдаа орсон байна. Үүний үр дүнд өвлийн оргил ачааллын үед хүн хүчгүйдэхийн зовлонг амсахааргүй болсон гэсэн үг. Бид өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлыг долоон бүлэгт хувааж төлөвлөөд, графикийн дагуу ажил маань 100 хувийн биелэлтэй байна. Өнөөдөр л гэхэд манай станц 5 зуух, 5 турбины горимтойгоор ажиллаж байна. Диспетчерийн үндэсний төвөөс өгсөн графикийн дагуу төлөвлөгөө ёсоор өнөөдөр л гэхэд цахилгаан үйлдвэрлэл 490 МВт ачаалалтай, дулаан хангамжийн хувьд 10000 тонн/ц сүлжээний устай хотын халаалтыг хийж байна.

Үндсэн тоноглолын хувьд хоёр зууханд их засвар, хоёр зууханд дунд засвар, нэг турбинд их засвар, мөн хурц уурын хоёрдугаар секцийн шугамын их засвар, нэг илчит тэрэгний их засвар хийх төлөвлөгөөтэй байсан. IV дүгээр зуухны их засварыг дуусгаад, хүйтэн, халуун туршилт хийн ажиллагаанд залгасан. Графикийн дагуу ТГ-6 ийн их засвар арваннэгдүгээр сарын 10-нд дууснa. Илчит тэрэгний их засвар ОХУ-д хийгдэж буй. Дараа сард ирэх ёстой. Бүх ажил графикийн дагуу явж, өнөөдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 90 орчим хувьтай байгаа нь манай станц, үндсэндээ өвөлд бэлэн гэсэн үг.

**-Станц хэвийн ажиллахад үндсэн тоноглолын найдвартай ажиллагаанаас гадна нүүрсний нөөц чухал. Өнөөдрийн байдлаар станц хэд хоногийн нүүрсний нөөцтэй байна вэ?**

-Гэрээ ёсоор 2016 онд 3.3 сая тонн нүүрс татаж авахаар төлөвлөсөн. Одоогийн байдлаар 2.5 сая тонн нүүрс татчихаад байна. Графикийн дагуух гүйцэтгэлийг жилээр нь авч үзвэл хэвийн гэж дүгнэж болно. Засгийн газрын тогтоолын дагуу ДЦС өвлийн улиралд 20 хоногийн нүүрсний нөөцтэй байх үүрэг хүлээсэн. Дулааны IY станц 158 мянган тонн буюу 18 хоногийн нүүрсний нөөцтэйгөөр, үйлдвэрлэл хэвийн ажиллаж байна.

**-Монгол Улс эрчим хүчний хэд хэдэн эх үүсвэртэй ч гаднаас импортолсоор байгаа. Тэгэхээр асуудал зохицуулалтад байна уу. Эсвэл ДЦС-уудын хүчин чадал хэрэглээгээ хангаж чадахгүй байгаа хэрэг үү?**

-Манай улс импортын эрчим хүчийг хэрэглэж байгаа гол шалтгаан нь системийн давтамжийг тохируулах, оргил ачааллын үед тодорхой хувь хэмжээгээр оргил ачааллыг хаах, аваарь, саатал гарсан үед түр хугацаагаар импортын эрчим хүч авах шаардлагатай байдаг. Учир нь орой ажил тарах үеэр эрчим хүчний хэрэглээний ачаалал эрс нэмэгддэг атлаа үдшийн 22:00 цагаас хойш ачаалал буурч экспортын урсгал бий болдог. Энэ нь том хүчин чадлын зуух, турбин зэрэг тоноглолуудыг шөнийн ачаалал багассан үед байнга зогсоогоод байх боломжгүй. Ачааллыг хасаад хамгийн бага ачаалалтай ажиллуулсан ч гадагшаа цахилгаан урсгадаг асуудал байдаг. Өнөөдрийн байдлаар манай улсын эрчим хүчний техник, технологийн боломж ийм байна. Уг нь ачаалал, урсгалыг тохируулах гол станц нь усан цахилгаан станц байдаг л даа. Салхины станц нь салхиндаа захирагддаг учраас яг оргил ачааллын үед ачаалал авч чадахгүй байх тохиолдол байдаг.

Дээр хэлсэнчлэн манай станц долоон турбин, найман зуухтай атлаа өнөөдрийн байдлаар таван зуух, таван турбины горимтой ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл, хоёр турбин, хоёр зуухаа нөөцөд байлгаж байгаа гэсэн үг. Тэр хэрээр манайд нөөц байгаа. Их, дунд, урсгал засвар дуусч ашиглалтад хүлээн авсны дараа бидэнд эрчим хүч нэмж үйлдвэрлэх бололцоо гарна. Юуны түрүүнд дотоодынхоо цахилгааны хэрэглээг хангах нь чухал. Мэдээж бид төлөвлөснөөсөө илүү эрчим хүч үйлдвэрлэж, түүнийгээ зах зээлд нийлүүлж гэмээнэ тэр хэрээр эдийн засгийн үр ашгийг тодорхой хувиар дээшлүүлж чадна.

**-Нийслэлийн хүн ам нэмэгдэхийн хэрээр эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх болсон. Жилээс жилд шинэ шинэ орон сууцны хорооллууд сүндэрлэж буй. Энэ өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг даах чадвар танай станцын хувьд ямар вэ. Ойрын үед техникийн шинэчлэл хийх, эсвэл өргөтгөх шаардлага бий юу?**

-Техник, тоног төхөөрөмж, хүчин чадлын хувьд хангалттай. Манай станц яг одоо 490 мВт-ын цахилгаан үйлдэрлэж байгааг та бид хоёр дэлгэцнээс хараад сууж байна. Станцын суурилуулсан хүчин чадал бол 703 мВт. Манай жилийн дундаж тоног ашиглалт 57 хувьтай гардаг. Тоноглолуудыг зогсоох шаардлага зайлшгүй гардаг. Графикт их, урсгал засвар хийх, үйлчилгээ хийх, зуны бага ачаалал болон шөнийн бага ачааллын үед тоноглолуудыг зогсоодог. Мөн аваар, саатлын үед тоноглол зогсдог. Импортын гэрээг биелүүлэхийн тулд манай станцын ачааллыг хасч бага ачаалалтай ажиллуулдаг. Салхин станц ч мөн манай станц бүрэн хүчин чадлаар ажиллахад нөлөөлдөг.

> ...XXI зуун бол техник технологи, инноваци, шинэчлэлийн зуун. Энэ бүхэнтэй хөл нийлүүлэх нь миний, бидний, станцын цаашлаад эрчим хүчний салбарын зорилго. Станцын ерөнхий менежерийн хувьд технологийн шинэчлэл, эдийн засгийн өсөлт, ажилтан албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг цаг тухайд нь шийдэж явахын төлөө зүтгэх учиртай. Хамгийн гол нь тоноглолынхоо найдвартай ажиллагааг хангаж чадаж гэмээнэ үр дүнг нь та бид хамтдаа үзнэ шүү дээ...

**-Уучлаарай, би мэргэжлийн хүн биш учраас хар таамгаар асууж буй хэрэг. Шөнийн илүүдэл, ОХУ руу хямд өртгөөр нийлүүлдэг эрчим хүчээ Оюутолгойд нийлүүлж болдоггүй юм уу?**

-Энэ бол системийн нэгдсэн бодлогоор шийдэгдэх асуудал. Бид Оюутолгойд эрчим хүч нийлүүлж болно. Гэхдээ эхний ээлжинд БНХАУ-ын эрчим хүчний системтэй холбоотой ажиллаж, ямар нэгэн хэмжээгээр манай төвийн эрчим хүчний системээс Оюутолгойг цахилгаанаар хангах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Оюутолгойгоос тавих шаардлагыг ч ойлгож байна. Тасралтгүй, найдвартай байх ёстой. Бид Эрдэнэтийн Уулын баяжуулах үйлдвэрийг олон жил цахилгаанаар хангалаа, болж л байсан. Та нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Бүх машин, бүх зуухаа 24 цагаар жилийн турш нэгэн зэрэг ажиллуулаад байх боломжгүй шүү дээ. Аль нэг нь саатвал, зогсвол, засварт орвол яах юм бэ. Техникийн бэлтгэл буюу нөөц гэж байх ёстой. Үүнийг л системийн бодлого гэж хэлээд байгаа хэрэг.

**-Иргэд танай станцаас гарч буй уурыг утаа гэж андуурах нь бий. Би тэдний нэг байв. Тэгээд станцын үйл ажиллагаатай танилцах үедээ учрыг олоод зогсохгүй байгальд ээлтэй технологи ашигладгийг нь мэдэж авсан. Энэ бол 2000 оны явдал. Түүнээс хойш байгальд ээлтэй байх тухайд ямар шинэчлэлтүүдийг нэвтрүүлсэн бэ. Ер нь БОАЖЯ-аас ямар шаардлагыг тавьдаг юм бол?**

-Манай станцид байгаль орчны хяналтыг хариуцсан Хяналтын алба гэж тусгай алба бий. Энэ алба манайхаас гарч байгаа утаанд хамт хаягдаж байгаа үнс, хорт хийн хэмжээ болоод нүүрсний дэгдэлт, тоосжилтод хяналт тавьж ажилладаг. Ер нь бол манай ДЦС Монгол Улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулсаар ирсэн. Мэдээж хэрэг бүх зүйл бүрэн төгс шийдэгдсэн гэж би хувьдаа хэлэхгүй. Гэвч бид аль болох байгаль орчинд ээлтэй байхыг гол зорилгоо болгон ажиллаж байгаа. Байгальд ээлтэй байх технологийг нэвтрүүлэх, тоног төхөөрөмжөө шинэчлэх тал дээр сүүлийн хэдэн жилд багагүй хөрөнгийг зарцуулсан.

**-Эрчим хүчний салбарын хууль тогтоомжид ДЦС-уудын эрхзүйн байдал ямар байдлаар тусгагдсан байдаг юм бол?**

-Манайх чинь төрийн өмчит компани шүү дээ. Тэгэхээр компанийн дүрэм, төрийн болон орон нутгийн өмчит хуулиар зохицуулагддаг юм.

**-Жилийн жилд станц, уурхайнуудын хооронд өр авлагын асуудал яригддаг. Та ямар өр, авлагатай аж ахуйн нэгж хүлээж авав. Нууц биш бол?**

-Манай станц сүүлийн жилүүдэд хуримтлагдсан өрийн хэмжээг жилээс жилд буулгасаар ирсэн. Тодруулж хэлбэл, станц тухайн сардаа хэрэглэсэн нүүрснийхээ үнийг төлөхийн сацуу хуримтлагдсан өрнөөсөө тодорхой хувийг буулгах арга хэмжээг давхар авч яваа. Ажил хүлээж авснаас хойш өр нэхсэн уурхайн захирал миний өрөөнд орж ирээгүй. Станц өнөөдрийн байдлаар шинээр тавьсан өргүй гэж хэлж болно.

**-Та станцын дарга ч гэлээ байгууллагын хувьд ерөнхий менежер нь. Сайн менежертэй байгууллага алздаггүй. Тийм хэмжээнд үнэлэгдэхийн тулд хамгийн түрүүнд хийх ажил, авах арга хэмжээ тань станцын хамт олон хийгээд эрчим хүчний салбарынханд сонин байх нь мэдээж?**

-XXI зуун бол техник технологи, инноваци, шинэчлэлийн зуун. Энэ бүхэнтэй хөл нийлүүлэх нь миний, бидний, станцын цаашлаад эрчим хүчний салбарын зорилго. Станцын ерөнхий менежерийн хувьд технологийн шинэчлэл, эдийн засгийн өсөлт, ажилтан албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг цаг тухайд нь шийдэж явахын төлөө зүтгэх учиртай. Хамгийн гол нь тоноглолынхоо найдвартай ажиллагааг хангаж чадаж гэмээнэ үр дүнг нь та бид хамтдаа үзнэ шүү дээ.

**-Яг одоо Монгол Улсын нэгдсэн төсвийг хэлэлцэж буй. Энэхүү төсөвт танай станцын ямар асуудлыг шийдэх хөрөнгө суух өгч байгаа бол. Эсвэл та бүхний хүргэх санал юу байна?**

-Ер нь манайд хамгийн түрүүнд шийдэх асуудал бол дотоод тарифын асуудал байгаа. Эрчим хүчний зохицуулах хороо үүнийг шийдвэрлэж өгдөг. Тиймээс ирэх онд гарах зардлаа бодитой батлуулж авах л нэн тэргүүний зорилго. Станц хөрөнгө, санхүүгийн хувьд баталгаатай байх аваас засварын ажлаа найдвартай хийнэ ингэснээр Монгол Улсаа эрчим хүчний найдвартай, хэвийн үйл ажиллагаагаар хангах нөхцөл бүрдэнэ шүү дээ. Хамгийн гол нь дотоод тарифын асуудал байна.

**-Тарифыг нэмэх нь эдийн засгийн хямралтай үед авах арга хэмжээ мөн гэж үү?**

-Гэхдээ дотоод тариф гэдэг чинь хэрэглэгчийн тариф биш шүү дээ. Өөр зүйл байдаг юм. Тодруулбал, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн цахилгаан, дулааныг хэрэглэгчдэд борлуулаад үнийг нэг дансанд төвлөрүүлдэг. Түүнийг үйлдвэрлэгчдэд хуваарилах механизмыг хэлж байгаа юм.

**-V дугаар цахилгаан станц баригдахгүй нь тодорхой болчихлоо. Танай ачаалал нэмэгдэнэ биз?**

-Нэмэгдэнэ. Эрчим хүчний төвийн системийнхээ 70 хувийг манайх дангаараа үүрээд явж байгаа. Ачааллын хэмжээ ямартай ч үүнээс буурахгүй байх. Ийм хэмжээний ачаа үүрэх нь бидний хувьд нэр төрийн хэрэг байдаг. Үүнийхээ төлөө ч зүтгэнэ.

**-Станцид ойрын үед өргөтгөл хийгдэх үү?**

-Яг одоо Станцын 2016-2022 оны бодлогын баримт бичгийг боловсруулах судалгааны ажлууд хийгдэж байгаа. Мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг ажилдаа орсон. Тэрхүү баримт бичиг хэрхэн яаж боловсрогдохоос станцын хувь заяа шийдэгдэнэ. Түүнээс миний саналаар өнөөдрөөс станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажил эхэлчихгүй шүү дээ. Өнгөрсөн жилүүдэд 123 мвт-ийн өргөтгөл хийгдсэн. Энэ бол станц дотор нэмж нэг үйлдвэр барьсан гэсэн үг. Би түрүүнд, үндсэн тоноглолын ашиглалт 57 хувьтай байдаг гэж онцолсон. Үүнийг нэмэх ёстой.

**-Тэг зогсолт гэж эрчим хүчнийхэн ярьдаг. Өнгөрсөн зун танайхыг тэг зогсолт хийлээ гэж сонсоогүй?**

-Манайх сүүлийн хэдэн жил тэг зогсолт хийгээгүй. Харин хэсэгчилсэн зогсолт хийсэн.

**-Энэ нь том амжилт уу?**

-Энэ бол том амжилт. Тэг зосголт гэдэг чинь бүх юм зогсоно. Ийм зогсолтыг хийлгүйгээр тодорхой хэмжээгээр үйлдвэрлэлээ явуулж, хэрэглэгчдийнхээ аа тухыг хангана гэдэг том амжилт.

**-Үнэнийг хэлэхэд, таныг эрчим хүчний салбарын хүн гэдгийг ярианаас тань анзаарлаа. Анхбаяр гэж хэн юм бэ гэдгийг сонирхох уншигч цөөнгүй бий?**

-Би эдийн засагч мэргэжилтэй, мэргэжлийнхээ дагуу докторын зэрэг хамгаалсан хүн. ОХУ-ын Эрхүү хотын Улс ардын аж ахуйн дээд сургуулийг төгссөн. Манай сургуулийг Монгол Улсын Сангийн долоон сайд төгссөн байдаг юм. Ийм сайхан сургуулийг төгссөндөө, тэнд докторын зэрэг хамгаалсандаа баяртай явдаг. ДЦС-тай хувь заяагаа холбоод арав гаруй болж байна. Сүүлийн жилүүдэд станцынхаа эдийн засгийн албыг толгойлж ажиллаж байлаа. Тэгэхээр намайг гадны хүн гэж хэн ч хэлэхгүй биз дээ. Манай алба станцын төлөвлөлтийг хариуцдаг. Хэчнээн хүний бүрэлдэхүүнтэй, хэчнээн тоноглолтойгоор хэчнээн хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх вэ гэдгийг тооцоолж гаргаж байсан учраас станцын маргаашийг олж харах нь надад асуудал биш. Харин ч урамтай, дөхөм байна. Тэгээд ч эрчим хүчний салбарыг эдийн засгаар удирдах шаардлага тулгарч буй. Төр, засгаас авч хэрэгжүүлсэн олон төсөл хөтөлбөрийн хүрээнд станцын үндсэн тоноглолын төлөв байдал сайжирсан. Олон ч төсөл хөтөлбөр хэрэгжсэн. Одоо харин тоноглолын найдвартай ажиллагаан дээр нэмээд эдийн засгийн үр ашигтай ажиллагаа чухлаар тавигдаж байна.

# ОНЦЛОХ ХУУДАС

**Сенсаацийн эргэн тойронд**

# ЦАГААН ТАХЛЫН ХАР СҮҮДЭР НӨМӨРСӨӨР Л...

Сүүлийн үед манай улсад хар тамхи, мансууруулах бодистой холбоотой хэрэг газар авч, үүнд донтогсдын тоо ч улам бүр нэмэгдсээр байна. Зарим шөнийн цэнгээний газар, баар, караоке мансууруулах бодис, хар тамхины “үүр уурхай” боллоо гэх мэдээлэл ч тасрахаа болилоо. Урлаг соёлын алдартнууд, хүүхэд залуусын дуртай хамтлагийн гишүүд, өсвөр насныхан хэрэглэсэн, хадгалсан, зөөсөн гэсэн үндэслэлээр ял сонсч байна. Бүр бүлгээрээ урьдчилан үгсэн тохиролцож хар тамхи хэмээх цагаан тахлыг эх орондоо зөөж ирсээр байгаа нь эмгэнэлтэй. Зөвхөн энэ сард гэхэд л хар тамхитай холбоотой олон хэрэг гарч, ЭЦГ, ТЕГ хамтран илрүүлсэн. Тиймээс энэ удаагийн “Онцлох хуудас” булангаа хар тамхи хэмээх цагаан тахлын хэргүүдийн эргэн тойронд бэлтгэлээ.

**“Гандан бороо” хочит Б-г хар тамхи хэрэглэсэн байхад нь саатуулав**

**2016.10.24**

Эрүүгийн цагдаагийн газрын албан хаагчид шуурхай ажилласны дүнд эрэн сурвалжлагдаж байсан “Гандан бороо” хочит Б-г саатуулав. Түүнийг Баянгол дүүргийн хоёрдугаар хороонд байрлах гэрээс нь саатуулжээ. Саатуулах үед тэрбээр мансууруулах бодис хэрэглэсэн байсан бөгөөд гэрээс нь Медафитамин төрлийн мансууруулах бодис илэрчээ. Тиймээс сэжигтэн Б-д Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд зааснаар хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн байна. “Гандан бороо” хочит Б өмнө нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148.3-т зааснаар буюу залилангийн хэргээр эрэн сурвалжлагдаж байсан юм. Тодруулбал, Б нь иргэн Г-аас 150 сая орчим сая төгрөгийн эд зүйлийг зээлээр авч, улмаар хугацаа нь дууссан боловч мөнгийг нь өгөлгүй айлган сүрдүүлсэн, заналхийлж байсан аж. Энэ талаар иргэдээс гомдол ирсний дагуу Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийнхэн түүнд Эрүүгийн хуулийн 148.3-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байжээ. Ийнхүү сэжигтэн Б буюу “Гандан бороо” гэгчийн залилан болон хар тамхины хэргийг нэгтгэн шалгаж эхэллээ. “Гандан бороо” хочит Б-г саатуулахаас өмнө Эрүүгийн цагдаагийнхан Шош, Доён Болд гэх нөхдүүдийг мөн саатуулсан байна. Өөрсдийгөө үндсэрхэг үзэлтэй хэмээн бусдад итгүүлж, ард иргэдийг айлган сүрдүүлж, шантаажлан мөнгө нэхдэг хэрэг цөөнгүй гардаг. Тиймээс цагдаагийн байгууллагаас иргэдийн айлган сүрдүүлж, мөнгө нэхдэг, дарамталдаг, дээрэмддэг этгээдүүдтэй хуулийн дагуу тэмцэхээр болжээ.

**Дэд сайд хар тамхины хэрэгт холбогдсон уу**

**2016.09.26**

Өнгөрсөн долоо хоногийн пүрэв гараг буюу есдүгээр сарын 22-ны өдөр Эрүүгийн цагдаагийн газрын Хар тамхитай тэмцэх хэлтсийн алба хаагчид хар тамхи худалдсан, худалдан авсан гэх найман хүнийг нийслэлийн Баянзүрх дүүргийн нутагт дэвсгэрээс баривчилжээ. Уг хэрэгт Б, Э, Э, Э нарын найман хүнийг сэжигтнээр татан шалгаж байгаа бөгөөд хэргийн газраас хар тамхи мансууруулах төрлийн бодис болох каннабисын төрлийн хатаасан ургамал, түүнийг татах хэрэгслийг эд мөрийн баримтаар хураан авсан байна. Дээрх этгээдүүдийн дөрөв нь өмнө нь хар тамхины хэрэгт холбогдон жил гаруйн хугацаанд хуулийн байгууллагад шалгагдаж, хавтаст хэрэг нь шүүх рүү шилжсэн байх хугацаанд давтан гэмт хэрэг үйлджээ. Зарим эх сурвалжийн мэдээлж буйгаар, энэ хэрэгт холбогдсон найман иргэний хоёр нь төрийн албан хаагч, тэдний дунд саяхан дэд сайдын албан тушаалд томилогдсон нэгэн нэр холбогдсон мэдээлэл байгаа юм. Тус мэдээллийн талаар ЦЕГ-ын Хэвлэл мэдээлийн төвийн дарга, цагдаагийн хурандаа Ц.Баатархүү өөрийн твиттер хуудсаар дамжуулан “Хар тамхи зардаг, худалдан авдаг хэсэг бүлэг хүмүүсийг барьсан. Энэ дунд ямар ч дэд сайд байхгүй ташаа мэдээлэл яваад байна” хэмээн тайлбар хийсэн байна. Гэтэл өөр эх сурвалж “Дэд сайд хар тамхи худалдан авч байгаад хэрэгт холбогдсон гэх мэдээлэл нь үнэний ортой. Энэхүү хэрэгт холбогдсон Б, Э нар нь төрийн албан тушаалтан хэмээн мэдээллэж байгаа юм. Ямартай ч, хар тамхины хэрэгт төрийн дээд албан тушаалтан холбогдсон гэх мэдээлэл үнэн байж болзошгүй болохыг ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн даргын албан бус тайлбар болон энэ хэргийн талаар анхлан мэдээлсэн хэд хэдэн иргэний сошиал дахь бичвэрийг устгуулсан байгаа зэргээс харж болох юм. Түүнчлэн хэргийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг ЭЦГ-ын дотоод хурлаар танилцуулаагүй, зөвхөн хариуцсан мөрдөгчид дэлгэрэнгүй мэдээлэл бий гэдгийг албан бус эх сурвалж мэдээлж байна.



**Ээж нь хар тамхи авчирч, хүү нь борлуулж байгаад баригдлаа**

2016.10.20

Энэ сарын 12-нд Замын-Үүд боомтоор Эрээнээс орж ирсэн Монгол Улсын иргэн Б гэгч иргэн 70 гаруй грамм жинтэй нунтаг цагаан бодис авчирчээ. Түүний авчирсан бодисыг хүү Н нь иргэн А, Д нарын хамт Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дахь нэгэн цэнгээний газарт борлуулж байгаад тагнуул, цагдаагийнханд баригджээ. Эдүгээ ЭЦГ-ын Хар тамхитай тэмцэх хэлтсийнхэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж буй бөгөөд ээж, хүү хоёрыг найзуудтай нь хамт ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангид саатуулсан байна. Цагдаагийн байгууллагаас өгсөн мэдээллээр тэд ашиг олох зорилгоор дээрх хэмжээний мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн болохыг тогтоогджээ. Тагнуулын байгууллагын эх сурвалжаас авсан мэдээллээр сэжигтэн Н ШШГЕГ-ын харьяа Хонхор дахь Баривчлах ял эдлүүлэх 431 дүгээр ангид хоригдож байхдаа мансууруулах бодис хууль бусаар олж авч, хэрэглээд баривчлагдсан хүмүүстэй танилцаж, тэднээс хар тамхи хилээр оруулж ирэн борлуулбал ашигтай гэсэн ойлголттой болсон аж. Улмаар ээжийгээ явуулж авчируулсан гэх мэдээллийг өгсөн юм. Өмнөд хөршөөс 10 гр “мөс”-ийг чанараас нь хамаараад 2000-3000 юаниар авч, Монголд 2-3 дахин нугалж борлуулдаг гэсэн мэдээлэл байна.

**Х.Бат-Ундралд оноосон хоёр жил хорих ялыг тэнсэн харгалзав**

**2016.10.10**

Хар тамхины хэрэгт холбогдож, Эрүүгийн хуулийн 192.1-ээр буруутгагдсан “Guys” хамтлагийн гишүүн Х.Бат-Ундралд холбогдох хэргийн шүүх хурал энэ сарын 10-ны өдөр Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд боллоо. Шүүхээс түүнийг гэм буруутай хэмээн үзэж, хоёр жил хорих ял ногдуулж мөн хугацаагаар тэнсэж хянан харгалзав. Энэ нь тэнсэнгийн хоёр жилийн хугацаанд ямар нэгэн гэмт хэрэг үйлдэхгүй. Хэрэв гэмт хэрэг үйлдвэл хорих ял эдэлнэ. Түүнчлэн Х.Бат-Ундрал шүүх хуралдааны үеэр хийсэн хэрэгтээ маш их гэмшиж байгаагаа илэрхийлээд уран бүтээлээрээ дамжуулан тамхины хор уршгийг залууст сурталчилна хэмээн амласан юм.

**Хар тамхины бүлгүүдийг илрүүлэн, саатууллаа**

**2016.10.19**

ЭЦГ-ын Хар тамхитай тэмцэх хэлтсийн алба хаагчид Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс, Буянт-Ухаа дахь гаалийн газартай хамтран энэ оны есдүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын иргэн А, Д нар урьдчилан үгсэн тохиролцож, БНХАУ-ын Бээжин хотоос хар тамхи, мансууруулах бодисын төрөлд орох ICE буюу мөс гэх бодисыг их хэмжээгээр “Чингис хаан” олон улсын нисэх буудлын хилийн боомтоор хууль бусаар нэвтрүүлсэн үйлдлийг илрүүлэн ЭХТА-ийн 188.2, 192.2-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Шалгалтын явцад хэрэгт холбогдогч А, Д нар ашиг олох зорилгоор дээрх мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан болохыг тогтоосон бөгөөд дээрх этгээдүүдийг ШШГЕГ-ын харьяа 461 дүгээр хорих ангид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч мөрдөн байцаалтын ажиллагаа үргэлжлүүлэн явуулж байна. Мөн ЭЦГ-ын Хар тамхитай тэмцэх хэлтсийн алба хаагчид Тагнуулын ерөнхий газартай хамтран энэ сарын 12-ны өдөр Монгол Улсын иргэн А, Д, М нар бүлэглэн Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хар тамхи, мансууруулах бодисын төрөлд орох ICE буюу мөс гэх бодисыг хууль бусаар олж авч, бусдад зарж борлуулж байсныг илрүүлэн ЭХТА-ийн 192.2-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Шалгалтын явцад дээрх этгээдүүд ашиг олох зорилгоор дээрх мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан болохыг тогтоосон бөгөөд иргэн Б-д ШШГЕГ-ын харьяа 461 дүгээр хорих ангид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч мөрдөн байцаалтын ажиллагаа үргэлжлүүлэн явуулж байна.

**Сэтгүүлчийн өнцөг**

# ХАР ТАМХИТАЙ “ХАТУУ ГАРААР” ҮЗЭХ ХЭРЭГТЭЙ ЮУ

Ж.ОТГОНМЯГМАР

Хар тамхины хэрэглээ болон хэрэг зөрчлийн тоо өсч буй нь, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрээд байна. 1999 онд хар тамхи хэрэглэгч 45 байсан гэдэг. Гэтэл 2015 онд хар тамхи, мансууруулах бодис хууль бусаар хэрэглэж, худалдаж, худалдан авсан 79 хэрэгт 169 хүн холбогдож байсан гэдэг. Харин энэ оны эхний зургаан сард гэхэд л хар тамхитай холбоотой 52 гэмт хэрэгт 120 иргэн холбогдож, шалгуулж эхэлсэн гэх мэдээлэл байгаа юм. Энэ нь хар тамхины хэрэглээ манай улсад ямар эрчимтэй өргөжин тэлж байгааг харж болохоор байна. Тэгвэл олон улсад хар тамхи хэрэглэгч нэг хүний цаана дөрвөн хүн байдаг гэж үздэг. Энэ жишгээр бодоод үзэхээр манай улсад олон мянган хэрэглэгч байж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна. Гэтэл энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож байгаа хүмүүсийн дийлэнх нь 18-35 настай байдаг нь хамгийн харамсалтай юм. Монгол Улсыг залуусын орон гэдэг. Өөрөөр хэлбэл, хүн амын 66 хувь нь 30-аас доош насныхан эзэлдэг. Тиймээс энэ асуудал улс орны хувь заяанд шууд заналхийлж байгаа гээд хэлчихэд хилсдэхгүй юм.

Тэгвэл ийнхүү аюулын харанга дэлдээд байгаа хар тамхитай тэмцэхийн тулд манай улс юу хийж байгаа вэ гэхээр эмгэнэлтэй дүр зураг харагдаж байна. Нөгөө нүцгэн гараараа гал унтраах гэж үзэж, тарж буй. Тухайлбал, Хар тамхитай тэмцэх үндэсний хөтөлбөр одоо болтол алга. Төрийн өндөрлөгүүд хяналт тавьдаг байх учиртай уг үндэсний хөтөлбөр байхгүйн дээр энэ хүрээнд хийгдэж байгаа дорвитой ажил нэг ч алга байна. Түүнчлэн хар тамхи гэдэг зүйлийг шинжилдэг, судалдаг лаборатори ч алга.

Мөн гэмт хэрэгтэн, хар тамхичин хоёрыг ялгадаг тогтолцоо гээд наад захын байх ёстой нэг ч зүйл манай улсад байхгүй. Энэхүү ажлын хүрээнд хар тамхийг хязгаарлах, хэрэглээг багасгах, эрэлт хэрэгцээг бууруулах гэсэн гурван үндсэн аргаас Монголд Эрүүгийн цагдаагийн хар тамхитай тэмцэх хэлтэс хязгаарлах ажлаа л хамгийн сайн хийж байна. Тухайлбал, өнгөрсөн есдүгээр сарын 22-ны өдөр Эрүүгийн цагдаагийн газрын Хар тамхитай тэмцэх хэлтсийн алба хаагчид хар тамхи худалдсан, худалдан авсан гэх найман хүнийг нийслэлийн Баянзүрх дүүргийн нутагт дэвсгэрээс баривчилсан, өчигдөр Эрүүгийн цагдаагийн газрын албан хаагчид шуурхай ажилласны дүнд эрэн сурвалжлагдаж байсан “Гандан бороо” хочит Б-г саатуулсан. Түүнийг саатуулах үед тэрбээр мансууруулах бодис хэрэглэсэн байсан бөгөөд гэрээс нь медафитамин төрлийн мансууруулах бодис илэрсэн гээд олон жишээ дурьдаж болно.

Тэгвэл хар тамхинаас урьдчилан сэргийлэх ажил хамгийн муу, зарим тохиолдолд бүр эсрэгээрээ “сурталчилгаа” их хийгдэж байна. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн байгуулллага, цагдаагийн газартай хамтран хар тамхины эсрэг сурталчилгааг тогтмол хүргэдэг ч нийгэмд, залууст тийм хүчтэй нөлөө үзүүлж чадахгүй байгаа. Харин гадаадад болон Монголд алдартай дуучин, тамирчид урлаг соёлын одод хар тамхи хэрэглэсэн, улмаар шоронд орсон зэрэг мэдээлэл тэдэнд очих нь элбэг байгаа юм. Манай улсад гэхэд “Дижитал” хамтлагийн дуучин Ш.Батбаяр буюу Баавар, Д.Манлайжаргал гээд хүүхэд залуусын сонсох, даган дуурайх дуртай олны танил хүмүүс хар тамхины хэрэгт холбогдсон. Хамгийн сүүлийн жишээ гэхэд ”Guys”-ийн Х.Бат-Ундрал хар тамхины хэрэгтэй холбогдож шүүх хурал энэ сарын 10-ны өдөр болж, шүүхээс түүнд хоёр жилийн тэнсэн харгалзах ял оноосон. Тэгвэл эрхэм дуучин маань энэ нь тэнсэнгийн хоёр жилийн хугацаанд ямар нэгэн гэмт хэрэг үйлдэхгүй байж чадвал хорих ял авахгүй гэсэн үг. Тэгвэл ийнхүү хар тамхины хэрэгт холбогдсон олны танил хүмүүст тэнсэн харгалзах биш албадан эмчилгээ хийдэг байж яагаад болохгүй гэж. Тэнсэн харгалзах хугацаандаа хүүхэд, залууст энэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх бодисны хор хөнөөлийг өөрийн хөрөнгөөр олон удаагийн давтамжтайгаар сурталчлан таниулсан байх ёстой гэдэг шийтгэл байж болохгүй гэж үү.

ОХУ, Португаль, Голланд, Герман зэрэг улс энэ асуудалд либериал шинжтэй ялын бодлого баримталдаг. Өөрөөр хэлбэл, захиргааны журмаар торгох, албадан ажил хийлгэх, баривчлах зэрэг ял шийтгэл ногдуулдаг. Харин Зүүн өмнөд Азийн БНХАУ, Тайланд, Малайз гээд мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт хатуу хуультай улс орон ч байна. Нэг жишээ дурьдахад, 2003 онд гуравхан сарын хугацаанд 2300 хүнийг цаазаар авч байсан тохиолдол Тайланд улсад гарч байсан байдаг. Энэ мэт харгис хатуу хуультай байдаггүй юм гэхэд нэн яаралтай хар тамхины асуудлыг үндэсний хэмжээнд авч үзэж, тэмцэх шаардлагатай байна.

# ДЭЛХИЙ

## 173 сая евротой тэнцэх урлагийн бүтээлээ музейд хандивлажээ

1970-аад оны үед Францын нийслэл Парис хотоор анх аялах үедээ урлагийн бүтээл шимтэн цуглуулах болсон АНУ-ын Техас мужаас гаралтай хосууд тэр үеэс хойш цуглуулсан хэдэн зуун ширхэг урлагийн бүтээлээ Парисын урлагийн музейд хандивлахаар шийдвэрлэжээ. Тус бүтээлийн нийт үнэ нь ойролцоогоор 173 сая еврогоор үнэлэгдэх гэнэ. Үнэт эрдэнэсээ хандивлаж буй хосуудын тухайд Спенсер Хайс, Марлен Хайс нарын хосууд аж. Тэдний музейд хандивлах урлагийн бүтээл дунд Францын импрессионист зураач Эдгар Дегас, Италийн уран зураач Амедео Модильяни нарын 187 ширхэг уран зураг багтаж буй бөгөөд нийт үнэ нь 173 сая еврогоор үнэлэгдэх бүтээлийг “Музей Орсе”-д хандивлах албан ёсны үйл ажиллагаа Парист болжээ. Энэхүү үйл ажиллагаанд Францын Ерөнхийлөгч Франсуа Олланд оролцсон байна. Энэ үеэр Хайс “Эхнэртэйгээ хамт Техасын Гейнсвиллд амьдарч байхдаа Францаар аялах талаар нэг ч удаа бодож байсангүй. Гэвч 1971 онд анх удаагаа Парист ирэх боломж олдож, энэ гайхалтай улс оронд дурлаж эхэлсэн. Бид тэнгэрийн оронд заларсныхаа дараа бүх цуглуулсан урлагийн бүтээлээ францчуудад бэлэглэх болно” гэж ярьжээ. Хуримаа хийснээсээ хойш 60 жилийг хамтдаа туулсан Хайсын гэр бүл 19-20 дугаар зууны эхэн үе хүртэлх 600 гаруй уралгийн бүтээлийг эзэмшдэг бөгөөд тэдгээрийн нийт үнэ нь 350 сая евротой тэнцэх гэнэ. Цуглуулгынхаа тоог ч тэд үргэлжлүүлэн нэмэгдүүлсээр байгаа аж.



# ХИЛЛАРИ КЛИНТОН ТЭРГҮҮЛЖ БАЙНА

Б.ДАВААХҮҮ

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль орон нутгийн цагаар ирэх сарын 8-нд болох билээ. Энэ сонгуульд Ардчилсан намаас Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон, Бүгд найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп нар өрсөлдөж байгаа. Трампын хувьд бизнесийн арвин туршлагатай бол Хиллари улс төрийн асар их туршлагатай юм. Ямартай ч, америкчууд тэдний нэгийг ирэх сард сонгох учиртай. Нэр дэвшигчдийн хувьд гурван ч удаа улс төр, гадаад бодлогынхоо талаар халз мэтгэлцсэн байдаг. Халз мэтгэлцээнээс өмнө нэр дэвшигчдийн дэмжигчдийн хувь адил тэнцүү, маш бага хувийн зөрүүтэй байсан ч, сүүлийн үед Хиллари Клинтон рейтингээрээ илт давуу тэргүүлсэн үзүүлэлттэй болж ирэв. Тодруулбал, “ABC news” агентлаг Ерөнхийлөгчийн сонгуулийг угтан олон нийтийн дунд явуулсан санал асуулгын дүнг өчигдөр олон нийтэд мэдээлсэн бөгөөд үүнд эдүгээ 68 настай Хиллари Клинтон үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трампыг 12 хувийн зөрүүгээр тэргүүлсэн үзүүлэлттэй байлаа. Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтоны хувьд сонгуульд хэнийг дэмжих шийдвэрээ хараахан гаргаж амжаагүй болон Доналд Трампаас нүүр буруулсан бүгд найрамдахчууд хийгээд нам бус иргэдийн дэмжлэгийг авах үйл ажиллагаа явуулж эхэлсэн байх бөгөөд цаашдаа парламентын дээд, доод танхимд ч Ардчилсан намын гишүүдээ дэмжих бодолтой байгаагаа илэрхийлэх болсон билээ. Тэгвэл Америкт явуулсан олон нийтийн санал асуулгаар Хиллари Клинтоныг дэмжигчдийн хувьд 50-д хүрч, эсрэгээр Доналд Трампыг санал асуулгад оролцогсдын 38 хувь нь дэмжжээ.

Үүнээс 10 хоногийн өмнө явуулсан “Washington post” сонины олон нийтийн санал асуулгын дүнтэй энэ удаагийн судалгааг харьцуулахад Хилларig дэмжигчдийн хувьд дөрвөн хувиар өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн, цагаан арьст иргэдийн 47 хувь нь Трампыг дэмжсэн бол Хиллариг 43 хувь нь дэмжжээ. Өнгөрсөн удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулиар цагаан арьст иргэдийн дийлэнх нь Бүгд найрамдах намын нэр дэвшигчийг дэмжиж байсан гэдэг. Тэгвэл эмэгтэйчүүдийн 55 хувь нь Хиллариг дэмжсэн бол 35 нь Доналд Трампыг дэмжиж байна. АНУ, Мексикийн хил дээр хана босгоно, лалын шашинтнуудыг хил нэвтрүүлэхгүй, хууль бус цагаачдыг албадан гаргана гэх мэт олон нийтийн дунд шүүмжлэл дагуулсан мэдэгдлийг хийж, улмаар сүүлийн үед эмэгтэйчүүдийг гутаан доромжилсон хэргээр дэмжигчдээ алдаад буй Доналд Трамп сонгуулийн уур амьсгал өрсөлдөгчийнх нь талд эргэж буй энэ үед ч бууж өгөхгүй гэдгээ мэдэгдсээр байна.

АНУ-ын энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд “үл таалагдах рейтинг”-тэй хоёр нэр дэвшигчийн хэн нь ялалт байгуулах нь дэлхий нийтийн анхаарлын төвд байсаар байна.

## Гаитигийн шоронгоос 172 ялтан орголоо

Гаитигийн нийслэл Порт-о-Принс хотоос хойш 45 км зайтай орших Аркахай хотын шоронгоос 170 гаруй хоригдол оргожээ. Хоригдлууд таван буу хулгайлан оргон зугтахдаа нэг хуяг болон нэг хоригдлын аминд хүрсэн байна. Тус улсад байрласан НҮБ-ын энхийг сахиулагчдын тусламжтайгаар хоригдлуудыг хайж эхэлжээ. Шоронд бослого үймээн дэгдсэний улмаас хоригдлууд оргосон гэж Гаитигийн Засгийн газар мэдэгдлээ.
Тус улсын Хуульзүйн сайд Камиль Эдуард Жуниор хэлэхдээ “нэг хуяг амь үрэгдсэн. Гурван хоригдол шархадсаны нэг нь шархаа даалгүй амьсгал хураасан” гэв. Одоогоор 11 хоригдлыг баривчлаад байгаа аж. Шоронгийн ойролцоох замууд дээр цагдаа цэргүүдийг байрлуулсан байна. Гэхдээ тус шоронгийн хоригдлууд нь шоронгийн дүрэмт хувцас өмсдөггүй учир хоригдлуудыг жирийн иргэдээс ялгахад амаргүй байгаа аж.Гаитигийн шоронгуудын дийлэнх нь хэт олон хоригдолтой байдаг бөгөөд хоригдлууд урьдчилан хорих төвүүдэд олон жилийг өнгөрүүлдэг байна.

## Доналд Трампын нүцгэн баримал 22 мянган ам.долларын үнэ хүрчээ




Өнгөрсөн амралтын өдөр Лос-Анжелес хотод болсон дуудлага худалдааны явцад АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд Найрамдах намаас нэр дэвшигч, тэрбумтан Дональд Трампын нүцгэн хөшөө 22 мянган ам.долларын үнэ хүрчээ. Алдартнуудын эд зүйлийг дуудлагаар худалддаг “Julien's Auctions” компани уг баримлыг худалдсан байна. Уг баримлыг нэрээ нууцалсан нэгэн эрхэм худалдан авсан бөгөөд тус дуудлага худалдааны “хамгийн их анхаарал татсан бүтээлүүдийн нэг” байжээ.

Эрс ширүүн мэдэгдлээсээ болж шүүмжлэлд өртөх нь олонтаа Доналд Трампын эсрэг сурталчилгааны нэг хэлбэр болох уг нүцгэн баримал АНУ-ын томоохон хотуудаар тойрч байсан удаатай. Зохион байгуулагчид өмнө нь “Нүцгэн Трамп” баримал 10-20 мянган ам.долларын үнэ хүрнэ хэмээн тооцож байсан ч, энэ удаа 22 мянган ам.доллароор зарагдсан нь санаанд оромгүй дүн байсныг онцолж байна.
Тус бүтээлийг Калифорнийн ашгийн бус “Indecline” компани бүтээсэн бөгөөд том гэдэстэй гараа цээжиндээ авсан байдалтайгаар Доналд Трампыг дүрсэлжээ.
Баримал өмнө нь Нью-Йорк, Сийтл гэх мэт дөрвөн хотоор тойрч, олны анхаарлыг татаж байсан билээ.
Доналд Трамп АНУ-ын Ерөнхийлөгч болсон тохиолдолд хууль бусаар оршин суух 11 сая хүнийг хүчээр нутаг буцаана хэмээн амласан нь олон хүний эгдүүцлийг төрүүлсэн. Харин энэхүү дуудлага худалдаанаас олсон орлогын зарим хэсгийг цагаачдад чиглэсэн үйл ажиллагаа явуулах “Үндэсний цагаачдын форум” гэх байгууллагад хандивлах юм.

## Нэг хулганыг 20 мянган рупигаар тооцон шагнана

Индонезийн нийслэл Жакарта хүн амын нягтшил, байгаль орчны бохирдлоороо дэлхийд тэргүүлдэг томоохон хотуудын нэг. Тэгвэл Жакарта хотод хулгана утсгалын кампанит ажил өрнөж эхэлжээ. Ингэхдээ урамшууллын тогтолцоог бий болгосон байна.Тодруулбал, хулгана барьсан иргэнийг шагнан урамшуулах бөгөөд нэг хулгана тус бүрээр нь 20 мянган рупигаар тооцон урамшуулал олгохоор болжээ. Тус хотод хогийн сав хөглөрсөн гудамж талбай, ядуусын хороололд хулганууд олноороо үүрлэсэн байх нь энгийн үзэгдэл бөгөөд 10 сая хүн амтай нийслэл хотын өнгө үзэмжийг сайжруулах үүднээс “Хулгана устгах” үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн байна. Жакарта хотын албан ёсны вэб хуудаст хулганыг ямар байдлаар барих, урамшууллаа авахдаа хулганаа амьдаар барьсан байх эсэхийг нь тодорхой нийтлээгүй байсан хэдий ч, хулгана барихын тулд галт зэвсэг ашиглахгүй байхыг сануулсан байв.

## Пак Гын Хе Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулахыг хүсэв

БНСУ-ын анхны эмэгтэй Ерөнхийлөгч гэгддэг Пак Гын Хе улсынхаа Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, Ерөнхийлөгчийн албан тушаалд улиран сонгогдох боломжтой болгох санал гаргажээ. Одоогоо БНСУ-ын Үндсэн хуульд Ерөнхийлөгч нэг удаа таван жилийн хугацаагаар сонгогдох эрхтэй байдаг байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн нэг удаа л Ерөнхийлөгчийн албан томилогдох заалтыг Үндсэн хуульдаа тусгасан дэлхийн цорын ганц хөгжингүй орон нь БНСУ байжээ. Олон арван жилийн нэг хүний засаглалын дараа буюу 1987 онд ардчилсан нийгэмд шилжихдээ Өмнөд Солонгос ерөнхийлөгчийн сонгогдох хугацаанд ийм хязгаар тавьсан аж. Тэгвэл өнөөгийн Ерөнхийлөгч Пак Гын Хе өчигдөр мэдэгдэл хийж, Үндсэн хуулийн тус заалт цаг үеэсээ хоцрогдсон тул өөрчлөлт хийх цаг нь болсныг онцолсон байна. Тэрбээр “Зөвхөн нэг удаа таван жилийн хугацаатай сонгогддог үндсэн хуулийн заалт нь ардчилалын шилжилтийн үед тохирч байсан байх” хэмээгээд “Харин одоо энэ нь багадсан хувцас шиг болжээ” гэсэн байна. Мөн Пак Ерөнхийлөгч өөрийнх нь бүрэн эрх дуусахаас өмнө буюу 2018 онд багтааж үндсэн хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулахаа мэдэгдсэн юм. Гэхдээ Парк хоёр дахь удаагаа ерөнхийлөгчөөр сонгогдох боломжгүй гэдгийг ерөнхийлөгчийн алба мэдэгдсэн байна. Өөрөөр хэлбэл дээрх өөрчлөлт одоогийн ерөнхийлөгчид үйлчлэхгүй гэнэ.

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## "Гандан бороо" хочит этгээдэд дарамтлуулсан бол Эрүүгийн цагдаагийн газарт хандаарай

Эрүүгийн цагдаагийн газрын алба хаагчид 150 сая төгрөгийн залилан хийсэн этгээдийг мансууруулах бодис хэрэглэж байхад нь баривчилжээ. Тодруулбал, "Гандан бороо" хочит Б нь иргэн Г-ээс 150 сая орчим сая төгрөгийн эд зүйлийг зээлээр авч, мөнгийг нь өгөлгүй айлган сүрдүүлсэн, заналхийлж байсан аж. Энэ талаар иргэдээс гомдол ирсний дагуу Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийнхэн түүнд Эрүүгийн хуулийн 148.3-т зааснаар хэрэг үүсгэн шалгаж, эрэн сурвалжилж байжээ. Түүнийг Баянгол дүүргийн хоёрдугаар хороонд байрлах гэрээс нь саатуулах үед тэрбээр мансууруулах бодис хэрэглэж байсан гэнэ. Мөн түүний гэрээс Медафитамин төрлийн мансууруулах бодис олдсон ажээ. Иймд сэжигтэн Б-д Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд зааснаар хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн байна. Мөн "Гандан бороо" хочит Б гэгчид дарамтлуулж, эд хөрөнгөө алдсан иргэд Эрүүгийн цагдаагийн газарт хандах боломжтой юм байна. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэд Эрүүгийн цагдаагийн газарт хандахыг ЦЕГ-аас анхааруулав.

# УЛСЫН ХЭМЖЭЭНД ДОХ-ХДХВ ИЛРҮҮЛЭХ САЙН ДУРЫН 43 ТӨВ АЖИЛЛАДАГ

Н.БАТЗАЯА

*ХӨСҮТ-ийн ДОХ-ХДХВ-ийн тандалт судалгааны албаны дарга Ж.Даваалхамаас бэлгийн замын халдварт өвчний талаархи зарим зүйлийг тодруулла.*

**-Сүүлийн үед залуус бэлгийн замын халдварт өвчнөөр өвчлөх нь ихэссэн. Залуусын дунд ямар төрлийн өвчин зонхилж байна вэ?**

-Манай улсын бэлгийн замын өвчний халдвар авсан хүмүүсийн 454 хувь нь 18-44 насны залуус байдаг. Сүүлийн үед залуус дунд тэмбүүгийн өвчлөлийн тохиолдол ихэсч байна. Энэ насны залуус ихэнх нь оюутан байдаг. Тиймээс бид өнгөрсөн хавар "Оюутны эрүүл мэнд" аян зохион байгуулж, III-IV дүгээр курсийн оюутнуудад үзлэг хийсэн. Үзлэгт хамрагдсан 5000 гаруй оюутан залуусын 2.5 хувьд нь бэлгийн замаар дамжих өвчний халдвар илэрсэн. Мөн бэлийн замын халдвар авсан хүмүүсийн ихэнх хувийг ажилгүй иргэд эзэлж байна. Мөн уул уурхай, зам тээврийн салбарт ажиллаж байгаа иргэдийн ихэнх нь залуус байдаг. Эдгээр салбарт ажилладаг залуус гэр орноосоо урт хугацаагаар хол байх шаардлага гардаг. Тиймээс бид үүнд анхаарч ажиллана. Бид тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ажил олгогч нартай хамтарч ажиллах бодлого баримталж байна.

**-2005 оноос хойш төрөлхийн тэмбүү өвчин нэмэгдэх болсон. Олон улсын хэмжээнд урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авч байна вэ?**

-2005 онд төрөлхийн тэмбүү өвчний 52 тохиолдол бүртгэгдсэн. Энэ өвчин 2005 оноос өмнө огт бүртгэгдээгүй гэвэл биш. 1980-1990 оны үед төрөлхийн тэмбүү өвчний тохиолдол ховор, бараг гардаггүй хэлж болохоор байсан. Сүүлийн үед энэ төрлийн өвчин нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Төрөлхийн тэмбүү өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд бид жирэмсний хяналтын чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатай. Бидний судалгаа, шинжилгээнээс үзэхэд төрөлхийн тэмбүүгийн бүртгэгдсэн тохиолдлын 80 орчим хувь нь жирэмсний хяналтад хамрагдаагүй, хамрагдсан байсан ч шинжилгээ өгөөгүй тохиолдол их байна. Тиймээс бид төрөлхийн тэмбүүг бууруулахын тулд нийт хүн амынхаа дундах тэмбүүгийн тархалтыг бууруулах ёстой.

**-Бэлгийн замын халдварт өвчний шинжилгээг хаана өгөх боломжтой вэ?**

-Иргэд харьяаллынхаа дагуу тухайн дүүрэг, аймгийнхаа бэлгийн замаар дамжих халдварын кабинетэд үзлэг шинжилгээндүнэгүйхамрагдах боломжтой. Харин хөдөө, орон нутгаас хотод түр оршин сууж байгаа харьяалалгүй иргэд болон оюутан залуус Халдварт өвчин судлалын үндэсний төвд хандаж, үнэгүй шинжилгээ өгч болно. Мөн оюутны хотхонууд дээр өсвөр үеийн залуусын төв ажилладаг. Тэдгээр төв дээр бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл өгдөг. Ер нь бэлгийн замын халдварт өвчний эмчилгээ, үзлэг үнэ төлбөргүй байдаг. Ганцхан гадаадад сурахад эрүүл мэндийн магадлагаа авахад л тодорхой хэмжээний мөнгө төлдөг.

**-Залуус энэ төрлийн шинжилгээ өгөх гэхээр бичиг баримтгүй гээд үзэхгүй байх тохиолдол байдаг. ХӨСҮТ-д үзүүлэхэд заавал бичиг баримт шаардлагатай юу?**

-Бэлгийн замаар дамжих халдвар даатгалд хамрагдаагүй байдаг. Тийм учраас даатгалын дэвтэр шаарддаггүй. Улсын эмнэлгийн байгууллагууд даатгалын дэвтрийг шаардахгүй гэсэн үг. Харин бид бүртгэл мэдээллээ сайжруулахын тулд тухайн хүний регистрийн дугаарыг бүртгэж авдаг. Гэхдээ хувь хүний нууцын талаархи мэдээлэл хаашаа ч цацагдахгүй. Тиймээс иргэд миний мэдээлэл алдагдчихна гэж санаа зовох шаардлаггүй. Бид хувь хүний мэдээллийг чанд хадгалдаг. Тэгэхээр энд санаа зоволгүйгээр аль болох бэлгийн замын өвчнөөс урьдчилан сэргийлэх шинжилгээ өгч, үзлэгт хамрагдаххэрэгтэй. Мөнулсын хэмжээнд ДОХ-ХДХВ илрүүлэх сайн дурын 43 төв ажилладаг. Эдгээр төвүүдэд ДОХ-ХДХВ-ийн үзлэг, шинжилгээг үнэгүй хийлгэж болно.

**-Улаанбаатар хотын сайн дурын төв хаана байрладаг вэ?**

-Дүүргийн бүх нэгдсэн эмнэлэг дээр сайн дурын төвүүд ажиллаж байна. Мөн "Гранпри", "Бүсгүйчүүд" гэсэн хоёр хувийн эмнэлэгт байрладаг. Мөн эрсдэлт бүлэгтэй ажилладаг төрийн бус байгууллагад байдаг.

## Амаржихын асуудлаар цагдаад ханджээ

Нийслэлийн "Өргөө" амаржих газрын мэс заслын тасгийн тааз энэ сарын 5-нд нурсан талаар бид өмнө нь мэдээлсэн. Тус эмнэлгийн тааз нурсан шалтгааныг тодруулахаар дүгнэлт гаргахаар ажиллаж, энэ хугацаанд тус эмнэлгийн хагалгааг ЭХЭМҮТ рүү шилжүүлэн хийж буй юм. Тэгвэл албаныхны мэдээлснээр дүгнэлт гаргахын хажуугаар талууд үл ойлголцолд хүрчээ. Тухайлбал, гүйцэтгэгч компанийн зүгээс Мэс заслын тасгийн таазыг "Зураг төслийнхөө дагуу хийсэн" гэж харин нөгөө талаас эмнэлгийнхэн "Бид иим тааз хийгээгүй" хэмээн маргалдах болжээ. Ийнхүү эзэн холбогдогчийг нь тодруулах шаардлагатай гэж үзэн цагдаагийн байгууллагад хандсан байна. Улмаар энэ асуудлыг эхний ээлжинд цагдаагийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр болжээ. Тиймээс тус амаржих газрын асуудал хэзээ шийдэгдэж, хагалгаагаа үргэлжлүүлэх эсэх нь тодорхойгүй болжээ. Уг нь эмэгтэйчүүдийн мэс заслын өрөө бүхий өргөтгөлийг дөнгөж 2013 оны нэгдүгээр сарын 29-нд ашиглалтад оруулжээ. Албаныхны мэдээлж буйгаар гадаадын тусламжаар 7.2 сая төгрөгөөр "Цаст констракшн" компани гүйцэтгэсэн байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Зарим даваагаар том тэрэг зорчуулахгүй

Цас орж, хальтиргаа гулгаа үүссэнтэй холбогдуулан Архан аймгийн Цагаан даваат өнгөрсөн бямба гарагийн орой 22.00 цагаас хаасан. Тэгвэл уг даваат өчигдөр өглөө нээсэн байна. Гэхдээ зөвхөн жижиг тэрэг зорчуулахаар нээсэн гэдгийг жолооч нарт сануулж байна. Тус даваагаар том оврын автомашиныг тодорхой хугацаанд зорчуулахгүй байхаар болжээ. Үүнээс гадна Сэлэнгэ аймаг Тужийн нарс, Төв аймаг Хустайн даваа, Ногоон дов, Увс аймагт халтиргаа гулгаа ихээр үүссэн байгаа тул техникийн бүрэн бүтэн байдал, зуны дугуйгаа өвлийн дугуйгаар сольж зорчихыг албаныхан давхар сануулав.

## Хиймэл нуурын уснаас дээж авч шинжилгээнд хүргүүлэв

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг Хятадын 100 хувийн хөрөнгө оруулалттай "Шинь Шинь" холимог металлын ордын ойролцоох тогтоол уснаас аймгийн Мэргэжлийн хяналтын газар дээж авч биологийн төв лабораторид шинжлүүлэхээр өгчээ. Тогтоол ус буюу жижиг нуур нь уурхайн хаягдлын далангаас нэг км орчмын зайд байдаг гэх ба уг уснаас эвгүй үнэр, амт амтагдаж байгаа нь хятадын уурхайн хаягдлын далан сэтэрч ус руу орсон байж болзошгүй гэх дүүдлага цагпаагийн байгууллагад иржээ. Улмаар иргэний мэдээллийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газар шалгалт хийж уурхайн шингэн хаягдал нуур луу ороогүй тогтоосон хэдий ч дээжийг шинжлүүлэхээр иинхүү лабораторид хүргүүлжээ. Хиймэл нуур тогтсон энэхүү орд нь хуучнаар Мардай хэмээн нэрлэгддэг байсан Оросууд уран олборлодог байсан ажээ.

PHOTO NEWS







*Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 377 жилийн ой энэ сарын 29-нд тохионо. Ойг угтаж нийслэлийн анхны сууръ тавьсан газар Өвөрхангай аймгийн Бүрд сумын III дугаар багийн нутаг Их Монгол уулын бэл, Ширээт цагаан нуурын хөвөөнд орших Гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүллээ. Хүндэтгэлийн үйл ажиллагаанд УИХ-ын дарга М.Энхболд, НИТХ-ын дарга Ц.Сандуй, нийслэлийн Засаг дарга С.Батболд болон холбогдох албаны хүмүүс оролцсон. Нийслэлийн түүхт ойн өдрүүдийг тохиолдуулан 17 дахь жилдээ болж буй ёслолын үеэр Өндөр гэгээн Занабазарын дүрийг залж, Зүүн хүрээ Дашчойлон хийдийн тэргүүн хамба Ч.Дамбажав тэргүүтэй лам, хуваргууд ном айлдсан юм.*

## ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

- Цэвээн-өөлд овогтой Мөнгөнцогтын ҮЗ2101014552 улсын бүртгэлийн дугаартай 000129974 тоот гэрчилгээ бүхий ОА-БӨ сумын БД 25-11 тоот хувийн сууцны зориулалттай гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

- 2205012633 улсын бүртгэлийн дугаартай 00297 гэрчилгээний дугаартай Цэнд овогтой Цээсүрэнгийн орон сууцны өмчлөх эрхийн гэрчилгээ гээсэн тул хүчингүйл тооцов

NO STRESS

ОДДЫН ЦАГ



# Яширо Аки: “ЖАМААС” ДУУГ АНХ СОНСОХОД ЯПОНЫ ПОП ДУУТАЙ ТӨСТЭЙ САНАГДСАН

Орчуулсан Б.ДАВААХҮҮ

*Япон дууны хатан хаан гэгддэг алдарт дуучин Яширо Аки Монголын тал нутаг хийгээд өнгөрөгч зун манай улсад хийсэн тоглолтынхоо сонин хачинаас орон нутгийн мэдээллийн сайтдаа хэрхэн ярьсныг уншигчиддаа “Оддын цаг” булангаараа дамжуулан сонирхуулахаар бэлдлээ. Тэрбээр Д.Сосорбарамын шүлэг “Жамаас” дууг япон хэлнээ орчуулан дуулсан төдийгүй, Монгол Улсын соёлын Элчээр томилогдсон нэгэн юм. Дуучин Яширо Аки 2015 онд Монголд анх ирж байсан гэдэг. Улмаар түүний сэтгэлийг Монголын тал нутаг , нүүдэлчин ард түмний амьдралын хэв маяг эрхгүй татсан бөгөөд хөх тэнгэрийн доор, эгэл жирийн ард түмэнд өөрийн дуу хоолойгоо хүргэхийг зорьсон нь өнгөрөгч зун биеллээ олжээ. Ингээд Яширо Акин товчхон ярилцлагыг орчуулан хүргэж байна.*

**-Яагаад “Жамаас” дууг сонгон коверлох болов. Энэ асуултаас ярилцлагаа эхлэе?**

-Д.Сосорбарамын дуулснаар “Жамаас” дууг анх сонсох үед ая нь Японы поп дуутай төстэй санагдсан. “Жамаас” гэдэг нь “бодит үнэн” гэх утгыг илэрхийлдэг хэдий ч, япон хүмүүст ойлгомжтой байдлаар шууд орчуулагддаггүй. “Амьдралд хоёрхон үнэн байдаг. Нэг нь төрөх, нөгөө нь үхэх” гэх маягаар дууны үг бичигдсэн. Шүлгийн утга санаа нь туйлын гүн гүнзгий. “Амь нас гэдэг бурхнаас өгсөн зүйл. Бурхан түүнийг өгдөг учир өөрөө амиа егүүтгэж болохгүй, бусдыг хөнөөж болохгүй. Амь нас гэдэг цаг хугацаатайгаа ирдэг болохоор бурханд талархах хэрэгтэй”. Энэ бол “Жамаас” юм.

**-Дууны шүлэгт гүн ухаан шингэсэн байх шиг байна?**

-Яширо Аки гэдэг хүн 46 жил дуулахдаа ийм л мессэжийг хүмүүст хүргэхийг зорьж ирсэн. Тиймээс ч энэ дууг дуулахаар шийдсэн. Цаг хугацаа нь ч яг таарсан нь зол гэж боддог.

**-Энэ дууг дуулах үедээ хэн нэгнийг дотроо төсөөлдөг үү?**

-Аав, ээжийгээ дотроо бодон төсөөлж дуулдаг даа. Аав минь аль эрт өнгөрсөн. Харин ээж минь одоо сэтгэцийн өвчний улмаас хэвтэрт байдаг. Өчигдөр ээжтэйгээ уулзлаа. “Би байна ээж ээ. Яширо нь байна. Ээж, аавынхаа хайртай охин нь байна” гээд хэлтэл, урьдын адил танихгүй царай гаргаж байснаа гэнэт л “Битгий хэтрүүлж бай” гэж хэлж билээ. Сэтгэцийн өвчтэй болохоосоо өмнө ээж маань “Дандаа л завгүй ажиллах юм. Ядартлаа битгий ажилла, битгий хэт их ажилла” гэж үргэлж хэлдэг байсан юм. Өчигдөр түүнийгээ санасан байж магадгүй. Аав минь аль хэдийнэ мөнх бусыг үзүүлсэн. Харин одоо миний нас явж, тэр насыг нь туулан өнгөрч байна. Өмнө нь хөгшрөх болоогүй л гэж боддог байлаа. Харин одоо бол жам гэж боддог болсон.

**-Анх удаа Монголд тоглолтоо хийх ямар байсан бэ?**

-Долдугаар сарын 31-нд Улаанбаатар хотын Дуурийн театрт тоглолт зохион байгуулагдсан. Тус барилгыг дэлхийн хоёрдугаар дайн дууссаны дараа Японы олзлогдсон цэргүүд барьсан учраас бат бөх хийгээд гадаад болон дотоод засал нь ч тун гайхалтай санагдсан. Маш олон үзэгчид хүрэлцэн ирсэн шүү. Хөтөлбөр шахуу байсан учир гурван цаг орчим л дэлгүүр хэссэн. Тэгээд гудамжаар алхаж явтал “Тоглолтыг чинь үзсэн. Үнэхээр гайхалтай” гэж монголоор хэлэх хүмүүстэй таарч явлаа. Сэтгэл маш их хөдөлсөн. Бас наймдугаар сарын 3-нд Улаанбаатар хотоос 100 орчим км-т орших 13 дугаар зуун цогцолбор буюу Чингис хаан амьд сэрүүн ахуйдаа амьдарч байсан газрыг сэргээн засварлан аялал жуулчлалын зориулалтаар ашиглаж буй газарт очиж дуугаа дуулж, тоглолт хийж билээ. Хээр талын дунд нэг ч үзэгчгүй. Задгай тайзан дээр гараад дуулж эхэлтэл хаанаас ч юм май май гэх хонь, адуун сүргийн дуу сонстож байлаа. Салхи, тэнгэр, газар дэлхий, дуу хоолой нэгэн дор сүлэлдсэн сайхан тоглолт болсон. Нар жаргах үед хамгийн сүүлийн “Хүнаүта” дуугаа дуулчихаад л унтахаар явж билээ.

**-Монгол Улсын соёлын Элчээр томилогдсон гэсэн үү?**

-Наймдугаар сарын 1-нд Монголын Гадаад хэргийн яаманд тус албан тушаалд томилох үйл ажиллагаа болсон. Өмнө нь Монголын уламжлалт дуу хөгжмийг японжуудаа сонсгох боломж олдоосой гэж хүсдэг байлаа. Хөгжим, урлагийн арвин сан хөмрөгтэй улс шүү дээ. “Хөөмий” гэж мэдэх үү. Хоолойн хөгжим шүү дээ. Хоолойн гүнээс гарах хөгжмийн авиаг хөөмий гэдэг юм. Эцэс төгсгөлгүй үргэлжлэх өргөн уудам тал нутгаас тэр чимээ гарч байна уу гэлтэй салхины тусламжтайгаар гарах дуу авиаг хөгжим болгон хөгжүүлсэн юм шиг сонсогддог. Соёлын элчээр таван жилийн хугацаанд ажиллана. Тиймээс Япон, Монгол хоёр улсын хөгжмөөр дамжуулан соёлыг танилцуулах хэрэгтэй болов уу гэж бодож байна.

**-Та “Жамаас” дууг хэнд зориулахыг хүсч байна вэ?**

-Хүчирхийлэл, хүүхдээ хаясан, бага насны хүүхдүүд нэг нэгийгээ шоглосон, учир утгагүй аллагын хэргүүд сүүлийн үед ар араасаа л гарах боллоо. Амьдрал үнэхээр сайхан шүү дээ. Заавал ингэх хэрэгтэй гэж хүчээр сургахын оронд дуугаараа дамжуулан үүнийг илэрхийлэхийг хүслээ. “Жамаас” дууг заавал нэг удаа ч болов сонсч, өөрийгөө мэдрээсэй гэж хүсч байна.

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр 0
Шөнө -11

Нөгөөдөр

Өдөр -5
Шөнө -15

Өдрийн зурхай

**Намрын адаг шар нохой сарын Зургаан цагаан мэнгэтэй Цагаан луу өдөр. Ангараг гараг**

**Үс засуулбал:** Нүд бүрэлзэн улцайна

**Наран ургах, шингэх:** 07:30 - 17:52



*Тухайн өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахайболой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.*

ДУУЛГАХ СОНИН

## “Маамуу нааш ир” дууг өнөөдөр нэгэн зэрэг дуулна

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн шагналт хөгжмийн зохиолч Д.Лувсаншаравын хөгжим, С.Лхамсүрэнгийн шүлэг “Маамуу нааш ир” дуу зохиогдсоны 60 жилийн ой энэ онд тохиож байгаа билээ. Тэгвэл ойн ажлын хүрээнд өнөөдөр 11:00 цагт “Маамуу нааш ир” дууг Монгол орон даяар цэцэрлэгийн бүх хүүхдүүд нэгэн зэрэг дуулах юм байна. Мөн “Маамуу нааш ир” дууны хөшөөнд цэцэг өргөх ёслол 12:00 цагт болох бол тус ойд зориулсан “Хүндэтгэлийн тоглолт” 13:00 цагт Монголын Хүүхдийн ордонд болох ажээ.

Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

Turbold TBo



Олон жилийн өмнө нэг охинтой болзож билээ. Улиралдаа ганц түрхдэг аминаасаа илүү хайртай “Gucci” брэндийнхээ сүрчигнээс хамаа замбараагүй шүршээд замын түгжрэлээс болоод жаахан хоцроод очсон юм. Гэтэл нөгөө охин “Усанд ороод алга болчихсон юм уу. Мэдсэн юмаа нуль саван вок үнэртэж байна” гэдэг юм даа. Ха ха ха

## Б.Сарантуяа “30 жил урлагт” зүтгэснээ тайлагнана

Зууны манлай эстрадын дуучин, Поп хатагтай, МУГЖ Б.Сарантуягийн “30 жил урлагт” тоглолтоо энэ сарын 29-ний өдөр “Корпорэйт Конвэншн” зочид буудлын концертын их танхимд ганцхан удаа тоглох гэж байна. “Мөнгөн харандаа” хамтлагаас гараагаа эхэлж, 16 настайдаа урлагт хөл тавьсан тэрээр өнгөрсөн 30 жилийн хугацаанд 21 цомог гаргаж, 22 бие даасан тоглолт зохион байгуулж, зургаан удаа Монгол Улсаа бүтэн тойрч, 10 гаруй орны 20 орчим хотод аялан тоглолт хийжээ. Улмаар 30 жилийн 600 гаруй уран бүтээлээсээ шигшсэн 30 дуугаараа 23 дахь бие даасан тайлан тоглолтоо хийхээр төлөвлөсөн байна.

Тоглолтод Харанга, Хөх тэнгэр, Хурд, Никитон, Камертон, Хар сарнай зэрэг хамтлаг дуучид оролцох юм.


